

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 26 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 10.00 цагт эхэлж, 12.20 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалт явуулсан дүнгийн тухай	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын албан тушаалд Янгугийн Содбаатарыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, МУ-ын Ерөнхий сайд С.Батболдод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны газрын даргын, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны хэлтсийн даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтан нарт дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	1.Тогоочийн Лхагва, Мөнхөөгийн Мөнхболд, Өлзийбатын Сүхбаатар, Жигжидсэнгийн Цэвээндорж нарыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан технологийн газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэх, 2.Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын даргын албан тушаалд Жигжидсэнгийн Цэвээндоржийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжавт санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. 3.Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Шинэтгэлийн бодлогын газрын Хувийн хэвшил, шинэтгэлийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалд Чардагийн Энхтуяаг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Үндэсний статистикийн хорооны дэд даргын, Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн Ажлын албаны даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	1.Үндэсний статистикийн хорооны дэд даргын албан тушаалд Баатарын Эрдэнэсүрэнг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

		<p>2.Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны даргын албан тушаалд Шовоохойн Жаргалсайханыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн Захирагч Н.Ханойд санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>3.Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд Т.Бадралыг томилсон шийдвэр хууль бус учир Засгийн газрын шадар сайдад энэ тухай тоот бичиг явуулж, нягталсны дараа энэ асуудлыг шийдвэрлэхээр хойшлуулав.</p>
4	Засгийн газрын зарим агентлагийн төрийн үйлчилгээний албан хаагчдаас төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авсан дүнгийн тухай	Төрийн захиргааны төв байгууллагын салбар комиссоос 2009 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын 24 ажилтныг 1 дүгээр хавсралтаар, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын 3 ажилтныг 2 дугаар хавсралтаар тус тус төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэлд бүртгэх тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Байгаль хамгаалагчдаас төрийн албаны мэргэшлийн шалгалт авах тухай	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад орох байгаль хамгаалагчдад зориулсан сургалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран зохион байгуулж, 2010 оны 01 дүгээр сард багтаан байгаль хамгаалагч нараас Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг авахаар тогтов.
6	"Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар", "Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх журам", "Ерөнхий менежер менежер (нэгжийн дарга)-тэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар", "Менежер (нэгжийн дарга)-ийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлэх журам"-ын төслийн тухай	<p>"Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй, Ерөнхий менежер менежер (нэгжийн дарга)-тэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон тэдгээрийн биелэлтийг дүгнэх журмыг шинэчлэн батлах тухай"</p> <p>1."Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Ерөнхий менежер менежер (нэгжийн дарга)-тэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар, "Менежер (нэгжийн дарга)-ийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлэх журам"-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолоор баталсан заавар, журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх,</p> <p>3."Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар</p>

	<p>батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2002 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар тогтоол, “Журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2002 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>“Заавар, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”</p> <p>1.Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар”-ын “Нэг”-ийн 8.2-ыг “Тусгай захиалгат ажил, үйлчилгээ” гэж ерөнхий менежер, эсхүл менежерийн үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд чиглэгдсэн, хууль тогтоомж, төр, засгийн удирдах дээд байгууллагын бусад шийдвэрээр үүрэг болгосон ажил, үйлчилгээ болон тухайн салбарын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тухайн жилд гүйцэтгэхээр заасан ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн, ерөнхий менежер, эсхүл менежерийн тусгайлан сонгосон ажил, үйлчилгээг;” гэж өөрчлөн найруулах,</p> <p>2.Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г дүгнэх журам”-ын “Хоёр”-ын 14.1-д “Тухайн нийт ажил, үйлчилгээг шалгуур үзүүлэлт бүрээр бүрэн гүйцэтгэсэн бол 30, тухайн ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсэн боловч зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол 20-29, тухайн ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсэн боловч бүх шалгуур үзүүлэлтийг гүйцэд хангаагүй бол 14-19, тухайн ажил, үйлчилгээний хагасыг гүйцэтгэсэн бол 5-13, тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх талаар зарим арга хэмжээ авч эхэлсэн бол 1-4, тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх талаар ямар нэг арга хэмжээ аваагүй бол оноо (“О” гэж тэмдэглэнэ) өгөхгүй.” гэсэн, “Тухайн тусгай захиалгат ажил, үйлчилгээг шалгуур үзүүлэлт бүрээр бүрэн гүйцэтгэсэн бол 40, тухайн ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсэн боловч зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол 29-39, тухайн ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэсэн боловч бүх шалгуур үзүүлэлтийг гүйцэд хангаагүй бол 18-28, тухайн ажил, үйлчилгээний хагасыг гүйцэтгэсэн бол 7-17, тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх талаар зарим арга хэмжээ авч эхэлсэн бол 1-6, тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх талаар ямар нэг арга хэмжээ аваагүй бол оноо (“О” гэж</p>
--	--

		<p>тэмдэглэнэ) өгөхгүй.” гэсэн хэсгийг тус тус нэмэх,</p> <p>Энэ журмын “Зургаа”-гийн 6.1-ийн хоёр дахь хэсгийг “Төрийн албан хаагч, ерөнхий менежер, эсхүл менежерийн өгсөн үнэлгээтэй санал нийлэхгүй байвал энэ тухай үндэслэлийг тусгасан тайлбарыг ерөнхий менежер, эсхүл менежер бичгээр гаргаж өгнө. Энэ тохиолдолд талууд үнэлгээтэй холбоотой санал нэгдээгүй асуудлыг дахин авч үзнэ. Хэрэв ерөнхий менежер, эсхүл менежер түрүүчийн өгсөн үнэлгээг өөрчлөөгүй бол гэрээ дүгнэсэн Илтгэх хуудсанд тайлбарыг хавсаргаж, үр дүнгийн гэрээг дүгнэгдсэнд тооцно.” гэж өөрчлөн найруулах,</p> <p>3.Энэхүү тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Улсын Их Хурлын Тамгын газрын шинжээч Д.Цэрэнхандын гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	<p>1.”Д.Цэрэнханд нь цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагчаас чөлөөлөгдөн Улсын Их Хурлын гишүүний туслахаар ажиллаж байгаад улмаар тухайн улс төрийн албан тушаалаас төрийн үйлчилгээний албан тушаалд шилжин ажилласныг төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаад тооцох хууль зүйн үндэслэлгүй байх тул “Д.Цэрэнхандыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах тухай” Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 401 дүгээр захирамж үндэслэлтэй байна” гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл ТАТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.7-д заасны дагуу шүүхэд гомдлоо гаргах эрхтэй болохыг маргааны талуудад мэдэгдэх тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга асан П.Тунгалаг, мөн газрын Хэмжил зүйн хэлтсийн дарга З.Ганболд нараас гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	<p>1.Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 357 дугаар шийдвэрт Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3-т “...төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол...” гэдгийг “...төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод шинээр бий болсон чиг үүргийн тухай биш, харин түүний хуучин албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулах талаарх хууль зүйн зохицуулалт байх”-аар тодорхойлсныг жишиг болгон хэрэглэж, “Стратегийн удирдлага, төрийн захиргааны хэлтсийн үндсэн чиг үүрэгт Төрийн захиргааны удирдлагын газар (өмнөх нэрээр)-ын үндсэн чиг үүргүүд хэвээр хадгалагдан үлдсэн байх тул П.Тунгалагийн ажлын байрыг “сул орон</p>

	<p>тоо” хэмээн үзэж, түүнд сонгон шалгаруулалт зарласан нь буруу байна. Түүнчлэн 2007-2008 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр “А”, “В” үнэлгээ авсан байхад, “Албан тушаалаас чөлөөлөх, удирдах албан тушаалд томилох тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тушаалаар П.Тунгалагийг Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын үүрэгт ажлаас 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсөн нь үндэслэлгүй байна” гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.”Дүгнэлт гаргах тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2009 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолын 4 дэх хэсгийн “а” заалтыг хүчингүй болсонд тооцож, “Албан тушаалаас чөлөөлж, удирдах албан тушаалд томилох тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тушаалын “Нэг” дэх заалтаас “Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын үүрэг ажлаас Пүрэврагчаа овогтой Тунгалаг,” гэснийг хасах,</p> <p>3.Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл ТАТХ-ийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7-д заасны дагуу шүүхэд гомдлоо гаргах эрхтэй болохыг маргааны талуудад мэдэгдэх тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>1.Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 19 дүгээр заалтыг зөрчсөн байх тул “Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс байгуулах тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 235 дугаар тушаалыг, тус журмын 14-ийн “а”, 26, 27, 31, 32 дугаар заалтуудыг зөрчсөн байх тул “Удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэж, удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, дүгнэлт гаргах тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2009 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолын “Нэг”-ийн “Хэмжил зүйн хэлтсийн даргын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд 1.Гүнсэн овогтой Зоригоо, 2.Загдхүү овогтой Ганболд нарыг тус тус бүртгэсүгэй” гэсэн хэсгийг, энэхүү тогтоолын “Хоёр”-ын “...Хэмжил зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Гүнсэн овогтой Зоригоог нэр дэвшүүлсүгэй” гэсэн</p>
--	---

	<p>хэсгийг, салбар зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гаргасан “Албан тушаалаас чөлөөлж, удирдах албан тушаалд томилох тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 254 тоот тушаалын “Хоёр”-ын “...Хэмжил зүйн хэлтсийн даргаар Гүнсэн овогтой Зоригоог 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсугай” гэсэн хэсгийг тус тус хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.Үүнтэй холбогдуулан “Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс байгуулах тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 235 дугаар тушаалыг бүхэлд нь, “Удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэж, удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, дүгнэлт гаргах тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын дэргэдэх Салбар зөвлөлийн 2009 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолын “Нэг”-ийн “Хэмжил зүйн хэлтсийн даргын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд 1.Гүнсэн овогтой Зоригоо, 2.Загдхүү овогтой Ганболд нарыг тус тус бүтгэсүгэй”, “Хоёр”-ын “...Хэмжил зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Гүнсэн овогтой Зоригоог нэр дэвшүүлсүгэй” гэсэн хэсэг болон “Албан тушаалаас чөлөөлж, удирдах албан тушаалд томилох тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 254 тоот тушаалын “Хоёр”-ын “...Хэмжил зүйн хэлтсийн даргаар Гүнсэн овогтой Зоригоог 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсугай” гэсэн хэсгийг тус тус хүчингүй болгох,</p> <p>3.Стандартчилал, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулж явуулахыг Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэдэх ТАЗСЗ-д үүрэг болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	---